



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/88

Бөхт

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 105 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх “Нэгдсэн халаалтын шугамын өргөтгөл хийх ажлын зураг төсөв боловсруулах ажил”-ыг 1,800,000 (нэг сая найман зуун мянган) төгрөгөөр “Осиб ЗТ” ХХК-тай шууд гэрээ байгуулсугай.

2. “Нэгдсэн халаалтын шугамын өргөтгөл хийх ажлын зураг төсөв боловсруулах ажил”-ыг техникийн нөхцлийн дагуу стандартын шаардлагад нийцүүлэх гүйцэтгэхийг “Осиб ЗТ” ХХК-ны захирал (Ц.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

3. “Осиб ЗТ” ХХК-тай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Мөнхбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ